



**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Аудитын код: САГ-2018/27/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддрож
Утас: 261740 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn

Гэрээт аудитор Э.Энхбаатар
Утас: 261740 Цахим хаяг: egii0225@yahoo.com

Гэрээт аудитор Н.Сүнжидмаа
Утас: 261740 Цахим хаяг: sunjee_8206@yahoo.com

Улаанбаатар хот



Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Агуулга

1	Аудитын хураангуй тайлан.....	2
2	Аудитын гэрчилгээ.....	5
3	Аудитын тайлан.....	7
3.1	Оршил.....	7
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	7
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	8
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
3.5	Дотоод аудит.....	9
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
3.7	Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	11
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	12
3.9.1	Хариуцлага тооцох талаар.....	12
3.9.2	Зөрчилгүй санал дүгнэлт авсан байгууллагуудын талаар.....	13
3.9.3	Хязгаарлалттай санал дүгнэлт авсан байгууллагуудын талаар.....	13
3.9.4	Төсвийн талаар.....	13
3.9.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар.....	14
3.9.6	Үндсэн хөрөнгийн талаар.....	14
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	14
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	16
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	16
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	17
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	17
3.16	Үр өгөөжийн тооцоолол.....	18
4	Менежментийн захидал.....	19
4.1	Төсвийн талаар.....	20
4.2	Аудитаар илэрсэн асуудлын талаар.....	21
4.3	Үндсэн хөрөнгийн талаар.....	22
4.4	Нягтлан бодох бүртгэлийн талаар.....	23
5	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	24
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	24
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	25
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	26
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	27
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	28
6	Зөрчлийн нэгтгэл.....	30
7	Албан шаардлага.....	

01

ТӨСВИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
САЙД Д.СУМЪЯАБАЗАР ТАНАА

2018.04.25 № 1033
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна. Иймд хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0425SAG24.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитын гол асуудал

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн

- Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулиар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын төсвийн урсгал зардлыг 11,319.9 сая, хөрөнгийн зардлыг 16,184.1 сая, нийт төсвийг 27,504.0 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр хөрөнгийн зардлыг 15,085.3 сая, урсгал зардалд 13,255.1 сая, нийт 28,340.4 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 836.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг зөрчсөн байна.

- "Шивээ овоо" ТӨХК нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 1,847.6 сая төгрөгийн дансны авлага, 13,844.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.

- "Мон-Атом" ХХК нь ТУЗ-өөс эхний хагас жилд бүтэц, орон тоо, төсөв батлуулалгүйгээр 110.1 сая төгрөг зарцуулсан, 105.7 сая төгрөгийн тэтгэмж, цалин олгосон болон 225.7 сая төгрөгийн цалингийн зардлыг зөрүүтэй зэрэг зөрчлүүд байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8, НББОУС 37, санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, үнэн зөв байх, тохиолдсон байх, үнэлгээ, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0425SAG24.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3 Аудитын тайлан

3.1 Оршил

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд төсвийн талаар, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар, үндсэн хөрөнгийн талаар, харьяа байгууллагад илэрсэн алдаа зөрчлийн талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага


Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 05-наас 2018 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Цэгмиддорж, гэрээт аудитор Э.Энхбаатар, Н.Сүнжидмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 01/929 дугаар албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбарын хувьд ил тод, хариуцлагатай, аюулгүй, хүний эрүүл мэндэд халгүй, байгаль орчинд ээлтэй, харилцан ашигтай, хуулиа дээдэлсэн зарчмыг баримтлан уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилготой ажиллаж байна. Үүнд:


- Геологийн салбарыг хөгжүүлэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх;
- Уул уурхайн олборлох, баяжуулах, боловсруулах үйлдвэрийг байгуулах замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Түлш (эрчим хүчний нүүрснээс бусад)-ний хангамж, нөөцийн талаарх бодлого боловсруулах, газрын тосны хайгуул, олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тос боловсруулах, нүүрснээс шингэн түлш гарган авах үйлдвэрийн суурийг тавьж хөгжүүлэх, улмаар дотоодын боловсруулах үйлдвэрийг байгуулах;
- Байгалийн хий болон уламжлалт бус газрын тосны эх үүсвэрийн (нүүрсний давхаргын метан хий, шатдаг занар, тослог элс гэх мэт) талаарх судалгаа, хайгуул, олборлолтыг дэмжин хөгжүүлж, хийжүүлэх, шингэрүүлэх замаар гүн боловсруулалт хийх, Техник эдийн засгийн үзүүлэлт боловсруулах, боловсруулах үйлдвэр байгуулах;
- Салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхийг сайжруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Салбарын удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, тус салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар салбарын өрсөлдөх чадавхийг дээшлүүлэх;
- Уул уурхайн салбарт техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, байгаль орчинд халгүй дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зэрэг болно.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх хүрээний асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 17 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Төлөвлөсөн зарим арга хэмжээний биелэлтийг дараах байдлаар нэгтгэн харуулав. Тухайлбал;

- Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын жилийн тайлангийн баталгаажуулалт хийх ажлын биелэлт 101.9 хувь;
- Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын жилийн тайлангийн баталгаажуулалт хийх ажлын биелэлт 99.0 хувь;
- Уулын ажлын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх ажлын биелэлт 38.3 хувь;
- Уулын ажлын тайлангийн хяналт, зөвшөөрлийн тоо олгох ажлын биелэлт 96.4 хувь;



- Нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэх ажлын биелэлт 104.0 хувь;
- Зэсийн баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх ажлын биелэлт 105.0 хувь;
- Төмрийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх ажлын биелэлт 99.8 хувь;
- Алтны олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх ажлын биелэлт 117.0 хувь;
- Газрын тосны экспортын хэмжээг нэмэгдүүлэх ажлын биелэлт 92.7 хувь;
- Тусгай зөвшөөрлийн төлбөр төлөх үүрэг бүхий аж ахуйн нэгжүүдийг татварт бүрэн хамруулах, орлогын төлөвлөгөөг биелүүлэх ажил 102.0 хувийн биелэлттэй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 12 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.


Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгсөн болно.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг



алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “сул” гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/111 дүгээр тушаалаар дотоод аудитын хороо байгуулсан байна. Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх чиг үүргийг гүйцэтгэж байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2017 оны төлөвлөгөөгөөр 8 төрлийн аудит хийхээс 7 төрлийн аудитыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнээс Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсвийн орлого, зарлагын тооцоолол, санхүүжилтийн гүйлгээ, төсвийн тайлан тэнцэлд санхүүгийн дотоод аудит хийгдээгүй байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын хийсэн 5 төрлийн аудитын тайланг Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, 2 төрлийн аудитыг сайдад танилцуулсан байна.

Хүснэгт №1: Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	8	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	7	
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	7	
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	80
		Дүн (сая.төг)	696.2
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	80
		Дүн (сая.төг)	696.2

Эх сурвалж: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2017 оны тайлан


Байгууллагын хүний нөөц, боловсон хүчний чиглэлээр батлагдсан тушаал, шийдвэрийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаа, гадаад сургалт болон албан томилолтын зардалтай холбоотой нийтлэг зөрчил дутагдал илэрсэн бөгөөд тухай бүр зөвлөмж өгч ажиллажээ.

Тайлант онд дотоод аудитын хороогоор хэлэлцүүлсэн асуудал байхгүй байна. Дотоод аудитын хороогоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудитын тайланг хэлэлцүүлж байх шаардлагатай байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын төсвийн багцад 2017 онд хэрэгжүүлэх 17 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Дээрх хуулиар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагуудын төвлөрүүлэх орлогын хэмжээг 255,829.1 сая төгрөгөөр өсгөх багцаас гүйцэтгэлээр 257,936.7 сая төгрөгийг төвлөрүүлжээ.



Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 27,504.0 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 11,319.9 сая, хөрөнгийн зардалд 16,184.1 сая төгрөгийг баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт 28,340.4 сая төгрөг зарцуулж, төсөв 836.4 сая төгрөгийн хэтрэлттэй байна. Урсгал зардалд 13,255.1 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 1,935.2 сая төгрөгийн хэтрэлттэй, хөрөнгийн зардалд 15,085.3 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 1,098.9 сая төгрөгийн хэмнэлттэй зарцуулсан байна.

Гадаад тусламжийн эх үүсвэрээс санхүүжих төслийн зардлыг 1,352.3 сая төгрөг төлөвлөснөөс 3,348.7 сая төгрөгийг зарцуулж төлөвлөгөөг 1,996.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэн бэлтгэж гаргаагүй байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт;
2. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт ;
3. Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл;
4. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл;
5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;
6. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт
7. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн зэрэг болно.


Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримтад хавсаргав.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд аудитын 8 чиглэлд нийт 12 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулж гэдгийг шалтгаан ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.



Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад Төсвийн ерөнхийлөн захирагчийн мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний нийт 16 байгууллагын санхүүгийн тайлан хамрагдсан байна.

Энэхүү санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан 7 байгууллагад “Зөрчилгүй”, 3 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгч, 2 байгууллага аудитын түүвэрт, 1 байгууллага аудитад хамрагдаагүй байна. “Эйч Эл Би Монголиа аудит” ХХК нь 3 байгууллагад Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр аудит хийсэн байна.


Хүснэгт №2 Санал дүгнэлтийн талаар

Д/д	Байгууллага	Зөрчилгүй	Хязгаар- лалттай	Түүвэрт хамрагдсан	Аудит хийгдээгүй	ХАК
1	Геологийн байгууллага			+		
2	УУЯ-ны хөрөнгө оруулалт			+		
3	“Геологийн судалгааны төв” ТӨҮГ	+				
4	“Геологийн төв лаборатори” ТӨҮГ	+				
5	“Замын-Үүдийн шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ	+				
6	“Эрдэнэс Монгол” ХХК	+				
7	Ашигт малтмал, газрын тосны газар	+				
8	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	+				
9	“Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК	+				
10	“Мон-Атом” ХХК		+			
11	“Шивээ овоо” ТӨХК		+			
12	“Эрдэнэс таван толгой” ХК		+			
13	Тогтвортой бичил уурхай төсөл				+	
14	“Эрдэнэс оюу толгой” ХХК					+
15	“Эрдэнэс метан” ХХК					+
16	“Эрдэнэс ассет менежмент” ХХК					+
	Нийт	7	3	2	1	3

3.9.1 Хариуцлага тооцох талаар

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэгдсэн “Мон-Атом” ХХК, “Шивээ овоо” ТӨХК, “Эрдэнэс таван толгой” ХК нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2.2.3-д А.А. Санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, ... албан тушаалтанд



холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ”, мөн санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасныг мөрдөж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх.

3.9.2 Зөрчилгүй санал дүгнэлт авсан байгууллагуудын талаар

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэсэн тайланд хамрагдсан “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан 7 байгууллагад 179,176.1 сая төгрөгийн 29 алдаа зөрчил илэрсэн байна. Аудитаар 121.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 179,054.8 сая төгрөгийн 28 зөвлөмж өгсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авах, Төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, дотоод хяналтыг сайжруулж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

3.9.3 Хязгаарлалттай санал дүгнэлт авсан байгууллагуудын талаар

- “Шивээ-овоо” ХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд нийт 3,457.3 сая төгрөгийн 13 алдаа зөрчил илэрсэн ба үүнээс 2,447.2 сая төгрөгийн 6 гүйлгээг залруулж, 991.7 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж, 18.4 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн байна.
- “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд нийт 11,400,840.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба үүнээс 11,353,425.5 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 47,415.1 сая төгрөгийн 7 зөвлөмж өгсөн байна.
- “Мон-Атом” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 481.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба үүнээс 391.2 сая төгрөгийн 5 зөвлөмж, 90.0 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авах, Төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, дотоод хяналтыг сайжруулж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

3.9.4 Төсвийн талаар

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын төсвийн урсгал зардлыг 11,319.9 сая, хөрөнгийн зардлыг 16,184.1 сая, нийт төсвийг 27,504.0 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр хөрөнгийн зардлыг 15,085.3 сая, урсгал зардалд 13,225.1 сая, нийт 28,340.4 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 836.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т заасныг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.



3.9.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж батлаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг, гэж заасныг хэрэгжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д заасныг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

3.9.6 Үндсэн хөрөнгийн талаар

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 125 дугаар тогтоолоор 583.0 сая төгрөгийн барилга, байгууламж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд шилжиж ирсэн байна. Эдгээр нь Багануур дүүрэг, Орхон, Дархан-Уул аймгуудад оршиж байгаа ба барилга, байгууламжын газар эзэмших эрхийн гэрчилгээ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нэр дээр бүртгэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх барилга байгууламжийн газар эзэмших эрхийн гэрчилгээний талаар зохих байгууллагаар шийдвэр гаргуулах талаар зөвлөмж хүргүүлэх.

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал


Аудитаар анхаарал татахуйц, цаашид нарийвчлан шалгах шаардлагатай дараах асуудлууд илэрсэн болно. Үүнд:

“Мон-Атом” ХХК:

- “Эрдэнэс Монгол” ХХК-иас авч байгаа зээлийн хүү жилийн 19.2 хувь буюу Монгол банкны бодлогын хүүгээс өндөр байгаа тул хүүгийн түвшин, үр өгөөжийг тус тус анхаарах шаардлагатай байна.
- Хамтарсан компанид БНЧУ-ын “Ураниум Индастри” ХК-иас хөрөнгө оруулалт хийх зорилгоор “Мон-Атом” ХХК руу шилжүүлсэн 2,000.0 мянган ам.долларыг гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээнд үйл ажиллагааны санхүүжилтийг эргүүлэн төлөх нөхцөлтэй болгон нэмэлт өөрчлөлт оруулсан, мөн “Мон-Атом” ХХК-иас хамтарсан компанийн дүрмийн санд оруулах анхны хөрөнгө оруулалт 51.0 мянган ам.долларыг “Ураниум Индастри” ХК-иас зээлийн гэрээгээр авахаар тохиролцсон боловч гүйцэтгэлд оролцоогүй “Төв Азийн Уран” ХХК-ийн төрийн төлөөллийн эзэмшлийн хувь, хөрөнгийн дүн тодорхойгүй байгаа зэрэг асуудлуудтай холбоотойгоор өр төлбөр нэмж үүсэх эрсдэл өндөр байна. Эдгээрээс шалтгаалж зээлийн үндсэн төлбөр, түүний хүү, торгуулийн төлбөр нэмэгдэж, Монгол Улсын Засгийн газрын өр төлбөр нэмэгдэхэд хүрч болзошгүй байна.

“Шивээ-Овоо” ТӨХК:

- “АСЕМ”-ийн дээд хэмжээний уулзалтанд хэрэглэсэн БНСУ-д үйлдвэрлэсэн “Hyundai universe luxury” маркийн 45 хүний суудалтай 2 ширхэг автобусыг “Би Эм лизинг” ХХК-иас 486.0 сая төгрөг /10 жилийн хугацаатай, жилийн 4.5%-ийн хүүтэй/-өөр худалдан авсан байна. Санхүүгийн түрээсийн хүү болон даатгалын зардалд 139.2 сая төгрөг төлөхөөр гэрээ байгуулсан байна. Гэтэл Сангийн яамнаас 1 автобусны худалдах үнийг 270.0 сая төгрөгөөр тогтоосон байна.
- “Шивээ- Овоо” ХК-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудит хийгдсэн үлдэгдлийг Сангийн яамны www.e-balance.mn цахим хуудсанд шивээгдсэн тайлантай тулгаж үзэхэд




2016 оны санхүүгийн аудитаар залруулагдсан буюу Засгийн газрын нэгдсэн тайланд орсон тайлангаас зөрсөн байна.

“Эрдэнэс таван толгой” ХК:

- “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2013 оны 1 дүгээр сарын 01-нээс 2016 оны 12 дугаар сарын 31-ний хүртэлх хугацааны санхүүгийн тайланд татварын шалгалт хийгдэж, 2017 оны 5 дугаар сарын 05-ны өдөр татварын улсын байцаагчийн 210022565 дугаартай актаар 11,301.3 сая төгрөгийн төлбөр тогтоосон байна. Компанийн удирдлага тухайн актыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа ба Татварын ерөнхий газрын дэргэдэх татварын маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан байна.

“Эрдэнэс Монгол” ХХК:

- Азийн хөгжлийн банкнаас 2016 онд “Эрдэнэс Монгол ХХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд 35,000.0 мянган ам.долларын зээл авах гэрээ байгуулж, 2016 онд 5,246.2 мянган, 2017 онд 1,661.5 мянган ам.долларыг тус тус хүлээн авч 2016 онд 57.6 мянган ам.доллар, 2017 онд 151.9 мянган ам.долларыг зээлийн хүүгийн өглөгт тооцсон байна. Зээлийг 2019 оны 9 дүгээр сараас эхлэн 12 жилийн хугацаанд зээлийн хүүгийн хамт төлнө. Зээлдэгч нь зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргийн гүйцэтгэлд Монгол Улсыг төлөөлж Сангийн сайд баталгаа гаргасан байна. Баталгааны эрх үүргийн хүрээнд Сангийн Яам нь “Эрдэнэс Монгол” ХХК-тай “Засгийн газрын өрийн баталгааны авлага барагдуулах гэрээ”-г 2016 оны 6 дугаар сарын 03-нд байгуулсан. Засгийн газрын өрийн баталгаа гаргах болсонтой холбогдуулж, Засгийн газрын өрийн баталгааны санд баталгаа гаргуулагч “Эрдэнэс Монгол” ХХК нь 5,250.0 мянган ам.доллар буюу 10,530.0 сая төгрөгийн шимтгэл байршуулж, тайлант хугацаанд 526.5 сая төгрөгийг шимтгэлийн зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 38 дугаар захирамжаар дэлхийд Монгол Улсын үнэлэмж, байр суурь, Монгол хүний үнэ цэнийг нэмэгдүүлэн таниулах бодлогыг зохицуулах үүрэг бүхий “Үндэсний брэнд”-ийн зөвлөл, зөвлөлийн ажлын албыг өөрийн бүтэц дотроо байгуулж, үйл ажиллагааны зардлыг төсвөөсөө санхүүжүүлэхийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасан байна. Үндэсний брэндийн зөвлөлийн ажлын албаны урсгал зардалд 2017 онд 344.5 сая төгрөг, гэрээний дагуу гадаадын байгууллагад төлөх төлбөрт 1,209.6 сая төгрөгийг “Эрдэнэс Монгол” ХХК-иас санхүүжүүлсэн байна. Нийт төсөв нь 1,728.5 сая төгрөгөөр батлагдсан байна.
- Засгийн газрын 2015 оны 449 дүгээр тогтоолын дагуу Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн 239 км хүнд даацын, тусгай зориулалтын авто зам, Гашуун сухайт боомтын дэд бүтцийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлсэнтэй холбоотойгоор Хөгжлийн банкнаас авсан 170,595.5 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг зохицуулсан 2/800 дугаар гэрээг 2015 оны 12 дугаар сарын 31-нд Хөгжлийн банк, Сангийн яамны төлөөлөлтэй баталгаажуулсан байна. Гэрээнд үндсэн зээлийг 2019, 2020 онд 2 үе шаттайгаар төлөх, хуримтлагдсан хүүг 2017 онд багтаан төлөх, үндсэн хүүг хуваарийн дагуу төлөхөөр заасан байна. 2017 онд хуримтлагдсан хүүгийн өглөг 21,151.4 сая төгрөгийг төлж 2,294.3 сая төгрөгийн хүүгийн үлдэгдэлтэй байна.
- Гашуун сухайтын авто замыг дагаж ирсэн боомтыг хил, гаалийн төрийн захиргааны байгууллага ашиглаж байгаа бөгөөд дээрх хөрөнгийн ашиглалт нь Авто замын ашиглалттай хамааралгүй, тус компанийн үйл ажиллагаанд зориулагдаагүй учраас



холбогдох газарт шилжүүлнэ гэж үзээд санхүүгийн тайлангийн эргэлтийн хөрөнгийн хэсэгт “борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө”-өөр бүртгэж, толилуулсан байна. Одоогоор дээрх биет хөрөнгөд элэгдэл хорогдол, үнэ цэнийн бууралтыг тооцоогүй байна.

- Швейцарийн Холбооны Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Тогтвортой бичил уурхай төсөл”-ийн санхүүгийн тайлан аудит хийгдээгүй нэгтгэгдсэн нь Швейцарийн Холбооны Агентлагаас буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй бүх төсөл, хөтөлбөрүүдийн зарцуулалтад санхүүжүүлэгчийн зүгээс жил бүр олон улсын аудит хийгддэг ба цаг хугацааны хувьд зөрүүтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлэхэд зарим тоон мэдээлэл өөрчлөгдөх эрсдэл үүсгэх магадлалтай байна. Үүнд:

Төв төрийн сангийн төсвийн хэлбэлзлийн тайлан эцэслэгдээгүй, нэгтгэлийн “Э-тайлан” програмаас хэвлэгдэж буй төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгийн зардлын төлөвлөгөөг давхардуулж оруулсан байна

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

- Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 2013 оны 291 дүгээр тогтоолоор баталсан журмыг шинэчилж сайжруулах талаар удирдлагын анхааралд хандуулсан асуудлын хэрэгжилтийг хянах;
- “Эрдэнэс таван толгой” ХК-ийн төрийн эзэмшлийн 65.2 хувь буюу 9,780.7 сая ширхэг хувьцааг нэрлэсэн үнэ 933 төгрөгөөр 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайландаа бүртгэн баталгаажуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал нарт Засгийн газраас үүрэг болгосны дагуу 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр санхүүгийн тайландаа залруулга оруулж эзэмшигчийн өмчийг 9,125,184.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тусгажээ.


“Эрдэнэс Монгол” ХХК дээр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг цаашид анхаарч, дараагийн аудитаар нарийвчлан үзвэл зохино. Үүнд:

- Азийн хөгжлийн банкнаас “Эрдэнэс Монгол ХХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг аудтад хамруулах;
- Эрчим хүчний экспортын “Шивээ энерги” цогцолбор төсөл. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 26-ний өдрийн 422 дугаар тогтоолоор Шивээ овоогийн нүүрсний ордыг түшиглэн эрчим хүчний цогцолбор байгуулан хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангаж, зохион байгуулах үүрэг бүхий төслийн нэгжийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дэргэд байгуулах зөвшөөрөл олгож, төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг батлагдсан орон тоо, төсөвтөө багтаан санхүүжүүлж шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг үүрэг болгосон.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар системийн хэмжээнд нийт 11,593,622.1 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, баталгаажуулав.

Үүнээс, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд болон өнз хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 836.4 сая



төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн ба 1 албан шаардлага өгч, 836.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 1 зөвлөмж хүргүүллээ.

Нэгтгэлд хамрагдсан харьяа 10 байгууллага, аж ахуйн нэгж, төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 11,592,785.7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс аудитаар 11,364,738.7 сая төгрөгийн 26 алдааг залруулж, санхүүгийн тайланг засуулснаас гадна 229.7 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага өгч, 227,817.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 44 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт – шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж ажилласан бөгөөд зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 92.8 хувьтай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 03/1910 дугаар албан бичгээр ирүүлсэн болно.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 639,774.0 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 12,795.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

Төлөвлөлтийн үе шатанд өмнөх оны нийт зарлагын дүнгийн 2 хувиар буюу 8,236.3 сая төгрөгөөр тогтоосон ба гүйцэтгэлийн үе шатанд тодорхойлсон материаллаг байдлын түвшингээс 4,559.2 сая төгрөг буюу 55.4 хувийн хэлбэлзэлтэй байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзлээ.


3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж **“Хязгаарлалттай”** санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинд харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлтэй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



3.16 Үр өгөөжийн тооцоолол

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 897.6 сая төгрөгийн үр өгөөжийн тооцооллыг хийж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.



4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандар болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Санхүүгийн хэлтсийн болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



4.1 ТӨСВИЙН ТАЛААР

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №1

ҮАГ-ын ажиглалт

2017 оны Төсвийн тухай хуулиар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын төсвийн урсгал зардлыг 11,319.9 сая, хөрөнгийн зардлыг 16,184.1 сая, нийт төсвийг 27,504.0 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр хөрөнгийн зардлыг 15,085.3 сая, урсгал зардалд 13,225.1 сая, нийт 28,340.4 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 836.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж зөрчих, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, ашиглал шамшигдал үүсэх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг мөрдөж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

4.2 АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДЛЫН ТАЛААР

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2

ҮАГ-ын ажиглалт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэсэн тайланд хамрагдсан “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан 7 байгууллагад 179,176.1 сая төгрөгийн 29 алдаа зөрчил аудитаар илэрсэн байна. Аудитаар 121.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 179,054.8 сая төгрөгийн 28 зөвлөмж өгсөн байна.

“Шивээ-овоо” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд нийт 3,457.3 сая төгрөгийн 13 алдаа зөрчил илэрсэн ба үүнээс 2,447.2 сая төгрөгийн 6 гүйлгээг залруулж, 991.7 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж, 18.4 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн байна.

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 11,400,840.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба үүнээс 11,353,425.5 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 47,415.1 сая төгрөгийн 7 зөвлөмж өгсөн байна.

“Мон-Атом” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 481.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба үүнээс 391.2 сая төгрөгийн 5 зөвлөмж, 90.0 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд: **Үнэн зөв байдал** - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх,

Хууль тогтоомж зөрчих, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх, ашиглал шамшигдал үүсэх, бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах

ҮАГ-ын зөвлөмж

Аудитаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар тодорхой ажил зохион байгуулж холбогдох арга хэмжээ авах, Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж, дотоод хяналтыг сайжруулж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.



4.3 Үндсэн хөрөнгийн талаар

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №3

ҮАГ-ын ажиглалт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 125 дугаар тогтоолоор 583.0 сая төгрөгийн барилга, байгууламж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд шилжиж ирсэн байна. Эдгээр нь Багануур дүүрэг, Орхон, Дархан-Уул аймгуудад оршиж байгаа ба барилга, байгууламжын газар эзэмших эрхийн гэрчилгээ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нэр дээр бүртгэлтэй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Дээрх барилга байгууламжийн газар эзэмших эрхийн гэрчилгээний талаар зохих байгууллагаар шийдвэр гаргуулах талаар зөвлөмж хүргүүлэх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

4.4 Нягтлан бодох бүртгэлийн талаар

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №4

ҮАГ-ын ажиглалт

Уул уурхайн, хүнд үйлдвэрийн яам нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг, гэж заасныг хэрэгжүүлэх, гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд бүртгэлээр тавих дотоод хяналт дутагдах, ашиглал шамшигдал үүсэх,

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д заасныг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй үйлчлүүлэгч байгууллагын удирдлага танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

5 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

5.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/МЯН.ТӨГ/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	302,191,884.1	489,455,566.8
МӨНГӨН ХӨРӨНГӨ	53,593,162.7	102,956,430.4
АВЛАГА	63,906,738.4	80,802,020.8
УРЬДЧИЛГАА	67,704,406.9	70,479,020.1
БАРАА МАТЕРИАЛ	82,222,826.6	193,795,073.6
НӨӨЦИЙН БАРАА	23,175,390.4	23,175,390.4
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	11,589,359.2	18,247,631.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,184,550,931.9	22,516,380,549.3
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,552,105,749.0	10,680,887,995.3
Урт хугацаат зээл	1,552,105,749.0	10,680,887,995.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	632,445,182.8	11,835,492,554.0
Биет хөрөнгө	112,131,086.0	104,195,998.5
Биет бус хөрөнгө	163,943,988.0	11,352,706,078.2
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	356,370,108.9	378,590,477.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,486,742,816.0	23,005,836,116.1
НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,293,232,853.0	1,001,204,570.8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	458,870,103.4	537,299,441.7
Богино хугацаат зээлийн өглөг	120,028.7	121,756,500.0
Өглөг	392,322,280.2	263,165,479.1
Урьдчилж орсон орлого	66,427,794.5	152,377,462.6
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	834,362,749.6	463,905,129.1
Урт хугацаат зээл	834,362,749.6	463,905,129.1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,193,509,963.0	22,004,631,545.3
Засгийн газрын хувь оролцоо	1,193,509,963.0	22,004,631,545.3
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,670,462.0	16,670,462.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	16,469,683.0	19,935,089.3
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	134,190.0	134,190.0
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	1,207,710.0	11,197,207,710.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	1,551,635,586.6	10,680,671,602.1
Хуримтлагдсан үр дүн	-394,058,709.9	88,517,036.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,451,041.3	1,495,455.8
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,486,742,816.0	23,005,836,116.1

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	354,873,852.3	1,161,392,787.3
ТАТВАРЫН ОРЛОГО	36,808,868.8	44,026,124.9
Бусад татвар, төлбөр, хураамж	36,808,868.8	44,026,124.9
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	307,008,883.7	1,099,556,936.2
Нийтлэг татварын бус орлого	303,739,835.5	1,096,208,237.1
Тусламжийн орлого	3,269,048.2	3,348,699.1
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,056,099.8	17,809,726.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	358,704,338.5	640,193,677.3
УРСГАЛ ЗАРДАЛ	355,111,339.9	640,193,677.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	170,887,798.9	372,113,429.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,268,870.5	4,847,049.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	480,103.2	469,207.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	351,819.0	361,534.5
Хангамж, бараа материалын зардал	328,628.5	472,267.9
Нормативт зардал	11,929.5	-
Эд хогшил, урсгал засварын зардал	54,787.4	195,274.9
Томилолт, зочны зардал	434,902.2	442,335.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	161,884,624.5	359,515,880.2
Бараа үйлчилгээний бусад зардал	2,072,134.3	5,809,879.1
ХҮҮ	4,189,150.7	3,653,420.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	180,034,390.3	264,426,827.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,592,998.6	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-3,830,486.2	521,199,110.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	959,428.8	863,276.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	187,521,943.5	31,670,467.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-190,393,000.9	490,391,918.4

5.3 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,444,242.1	-	99,444,242.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,284,423,888.5	-	1,284,423,888.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,383,868,130.6	-	1,383,868,130.6
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	34,833.3	-	34,833.3
Тайлант үеийн үр дүн	-190,393,000.9	-	-190,393,000.9
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,193,509,963.0	-	1,193,509,963.0
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,193,509,963.0	-	1,193,509,963.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,671,172.3	-	-7,671,172.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,185,838,790.7	-	1,185,838,790.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	44,414.4	-	44,414.4
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	817,764.0	-	817,764.0
Өмчид гарсан өөрчилөлт	20,327,538,657.8	-	20,327,538,657.8
Тайлант үеийн үр дүн	490,391,918.4	-	490,391,918.4
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,004,631,545.3	-	22,004,631,545.3

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	384,496,055.1	1,406,500,840.2
ТАТВАРЫН ОРЛОГО	36,808,868.8	44,026,124.9
Бусад татвар, төлбөр, хураамж	36,808,868.8	44,026,124.9
Бусад нийтлэг төлбөр, хураамж	36,808,868.8	44,026,124.9
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	336,432,135.5	1,344,392,290.1
Нийтлэг татварын бус орлого	333,163,087.3	1,341,043,591.0
Тусламжийн орлого	3,269,048.2	3,348,699.1
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,255,050.8	18,082,425.2
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	317,693,113.4	1,099,055,687.1
УРСГАЛ ЗАРДАЛ	317,693,113.4	1,099,055,687.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	137,673,699.0	834,123,563.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,646,365.7	34,743,315.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,038,990.5	8,810,608.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,161,707.5	5,603,246.7
Хангамж, бараа материалын зардал	21,098,159.7	33,450,768.0
Нормативт зардал	4,056.0	1,386.0
Эд хогшил, урсгал засварын зардал	82,335.6	215,126.2
Томилолт, зочны зардал	584,537.7	411,929.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,823,903.8	750,379,572.4
Бараа үйлчилгээний бусад зардал	233,642.4	507,610.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	180,019,414.4	264,932,124.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	66,802,941.8	307,445,153.1
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	916,645.5	2,264,693.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	15,954,234.9	20,252,617.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,954,234.9	20,252,617.8
Дотоод эх үүсвэрээр	15,954,234.9	20,252,617.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-15,037,589.4	-17,987,924.2
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	861,049.9	-240,093,961.2
Бусад эх үүсвэр	22,247,752.8	14,133,815.4
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	356,419.5	10,000.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	21,030,283.4	254,217,776.6
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	52,626,402.2	49,363,267.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	966,760.5	53,593,162.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	53,593,162.7	102,956,430.4

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,504,028.4	28,340,360.2	(836,331.8)	103.0
УРСГАЛ ЗАРДАЛ	11,319,900.4	13,255,117.4	(1,935,217.0)	117.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,754,037.4	9,691,334.1	(1,937,296.7)	125.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,042,489.2	3,042,019.2	470.0	100.0
Үндсэн цалин	2,154,319.8	2,153,848.8	471.0	100.0
Нэмэгдэл	622,522.1	622,521.9	0.2	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	210,509.2	210,510.5	(1.3)	100.0
Гэрээт ажлын хөлс	55,138.1	55,138.1	0.0	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	328,608.8	328,608.8	-	100.0
Тэтгэврийн даатгал	209,114.6	209,114.6	-	100.0
Тэтгэмжийн даатгал	29,873.5	29,873.5	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	23,898.9	23,898.9	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	5,974.7	5,974.7	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	59,747.1	59,747.1	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	269,230.5	232,813.4	36,417.1	86.5
Гэрэл, цахилгаан	36,927.0	17,705.7	19,221.3	48.0
Түлш, халаалт	97,812.0	96,658.8	1,153.2	98.8
Цэвэр, бохир ус	38,016.0	22,197.7	15,818.3	58.4
Байрны түрээс	96,475.5	96,251.2	224.3	99.8
Хангамж, бараа материалын зардал	221,962.7	217,440.3	4,522.4	98.0
Бичиг хэрэг	58,615.7	56,651.4	1,964.3	96.7
Тээвэр, шатахуун	76,416.8	75,145.1	1,271.8	98.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	59,389.6	57,750.2	1,639.4	97.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	855.4	720.0	135.4	84.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,685.2	27,173.7	(488.5)	101.8
Нормативт зардал	1,386.0	1,386.0	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,386.0	1,386.0	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	36,273.7	35,997.8	275.9	99.2
Багаж, техник, хэрэгсэл	4,815.4	4,729.3	86.1	98.2
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,138.4	2,283.5	(145.1)	106.8
Урсгал засвар	29,319.9	28,985.0	334.9	98.9
Томилолт, зочны зардал	157,407.6	157,393.5	14.1	100.0
Дотоод албан томилолт	157,407.6	157,393.5	14.1	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,544,928.9	5,523,925.1	(1,978,996.2)	155.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,460,030.1	5,449,926.8	(1,989,896.7)	157.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,772.0	2,700.0	72.0	97.4
Даатгалын үйлчилгээ	22,888.8	22,888.8	-	00.0
Тээврийн хэрэгслийн татвар	7,271.5	4,668.1	2,603.4	64.2
Тээврийн хэрэгслийн оношлогоо	531.1	497.9	33.2	93.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35,091.0	34,430.9	660.1	98.1
Газрын төлбөр	11,394.4	3,917.4	7,477.0	34.4
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,950.0	4,895.2	54.8	98.9



Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Бараа үйлчилгээний бусад зардал	151,750.0	151,750.0	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	151,750.0	151,750.0	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,565,863.0	3,563,783.2	2,079.8	99.9
Бусад урсгал шилжүүлэг	3,565,863.0	3,563,783.2	2,079.8	99.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	22,000.0	21,998.6	1.4	100.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,327,750.0	3,327,744.2	5.8	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	137,813.0	137,813.0	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	78,300.0	76,227.5	2,072.5	97.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,184,128.0	15,085,242.9	1,098,885.1	93.2
Барилга байгууламж	2,848,228.0	2,833,900.8	14,327.2	99.5
Бусад хөрөнгө	13,335,900.0	12,251,342.0	1,084,558.0	91.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	27,504,028.4	28,379,878.4	(875,850.0)	103.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,824,003.4	16,665,114.6	1,158,888.8	93.5
Улсын төсвөөс санхүүжих	17,824,003.4	16,665,114.6	1,158,888.8	93.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,327,750.0	8,366,064.7	(38,314.7)	100.5
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,477,750.0	3,477,750.0	-	100.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,850,000.0	4,888,314.7	(38,314.7)	100.8
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	1,352,275.0	3,348,699.1	1,996,424.1)	247.6
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	1,352,275.0	3,348,699.1	(1,996,424.1)	247.6
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2.0	2.0	-	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.0	2.0	-	100.0
Төсвөөс гадуур байгууллага	263.00	263.00	-	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.00	30.00	-	100.0
Удирдах ажилтан	182.00	182.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	51.00	51.00	-	100.0

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**